

## "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй" төсөл



### Төслийн зорилго, зорилт

"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй"/ХБХГИ/ төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн /ХБХ/ ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх явдал юм. Тус зорилгын хүрээнд дараах хоёр зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ХБХ-ийг илрүүлэх үндэсний болон орон нутгийн стандарт, механизмийг сайжруулах
- ХБХ-ийг тохирох боловсролын үйлчилгээ, сургалтын хэрэгслээр хангаж хөгжүүлэхэд нь гэр бүл болон боловсролын байгууллагуудыг чадавхжуулах

Тус төслийг ДЗМОУБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд Хараат бус судалгааны хүрээлэн зорилт нэгийн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна.

## **Төслийн хэрэгжих хугацаа**

Тус төсөл нь 2016 оны 6 сараас 2017 оны 9 сарын хугацаанд хэрэгжиж байна.

## **Төслийн үндэслэл**

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яамны /БСШУЯ/ тоо мэдээгээр 2014–2015 оны хичээлийн жилд бага, дунд сургуульд нийт 505,816 суралцагч суралцсан. Үүнээс ХБХ нийт суралцагчдын дөнгөж хоёр хувийг (11,072) эзэлж байна. Сургуулийн орчин нөхцөл хүртээмжгүй, багш мэргэжилтнүүдийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан улсын хэмжээнд ялангуяа хөдөө орон нутагт сургууль завсардаж буй хүүхдүүдийн дийлэнх хувийг ХБХ бүрдүүлж байгаа юм. Мөн оны тойм мэдээгээр нийт сургуулийн насны ХБХ-ийн 30 гаруй хувь нь(4,779) ямар нэг боловсролын үйлчилгээ авч чадалгүй сургуулийн гадна үлдсэн гэсэн тойм мэдээ байна.

Дээр тэмдэглэсэнчлэн тойм тоо мэдээг дурдаж болох хэдий ч манай улсад ХБ-ийг тодорхойлох нэгдсэн аргачлал, аргазүй дутмаг байгаагаас боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгаалал зэрэг салбар бүрийн тоо мэдээ хоорондоо ихээхэн зөрүүтэй байна. 2014 онд Хараат бус судалгааны хүрээлэн Японы Хамтын ажиллагааны нийгэмлэгийн судалгааны институтийн (JICARI) захиалгаар үндэсний хэмжээнд хийж гүйцэтгэсэн "Хөгжлийн бэрхшээл ба Боловсрол" судалгааны үр дүнгээр улсын хэмжээнд ХБХ-ийн талаарх мэдээлэл, тоо статистик ихээхэн зөрүүтэй, тодорхой бус гэсэн үр дүн гарсан. Сургуулийн түвшинд хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг ихэнх тохиолдолд багш нар өөрсдийн хувийн туршлага дээрээ үндэслэн тодорхойлж байгаа бөгөөд ашиглаж буй нэгдсэн арга аргачлал, хэрэглэгдэхүүн огт байхгүй байна.

2014 онд Эрүүл мэнд, БСШУЯ, Хөдөлмөр Нийгэм Хамгааллын яамны /ХНХЯ/ гурван сайдын хамтарсан тушаалаар манай улсад хүүхдийн ХБ-ийг тодорхойлох үүрэгтэй Эрүүл мэнд, Боловсрол, Нийгэм хамгааллын төв болон салбар комиссыг (ЭМБНХК) аймаг орон нутаг, нийслэл дүүргийн түвшинд байгуулсан. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл тус комиссын үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байна. Иймд хүүхдэд тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг эрт илрүүлж таних арга аргачлал үндэсний хэмжээнд зайлшгүй шаардагдаж байгаа юм. Тус хэрэгцээ шаардлагын үүднээс Хараат бус судалгааны хүрээлэн ХБХГИ төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд хүүхдийн бэрхшээлийг эрт илрүүлэх аргачлалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус аргачлал нь анхан шатны түвшинд /хороо, сургуулийн түвшинд/ хүүхдийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа бэрхшээлийг илрүүлэх энгийн аргачлал байх бөгөөд албан ёсны оношилох эрх бүхий ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүдийг илрүүлэх боломжтой болох юм.

Хараат бус судалгааны хүрээлэн өөрсдийн хариуцсан зорилтын хүрээнд дараах ажлуудыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн байна:

## **1. Суурь судалгаа**

Төсөл хэрэгжихээс өмнөх гарааны нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Нийслэлийн гурван дүүргийн зорилтот есөн сургуулийн багш, удирдлага, хорооны нийгмийн ажилтан, дүүргийн мэргэжилтэн, төрийн бус байгууллагын /ТББ/ төлөөлөл, ХБХ-ийн эцэг эхчүүдийг хамруулан нийт 312 асуумж, 60 хагас бүтэцлэгдсэн ярилцлагын дагуу мэдээлэл цуглуулах ажил 2016 оны 09 сард явагдаж дууссан.

Тус суурь судалгааны үр дүнгээр өнгөрсөн 2015–16 оны хугацаанд ХБХ-ийн үнэлгээтэй холбоотой ямар нэгэн ажил хэрэгжүүлсэн хороо, сургууль, дүүрэг байгаагүй бөгөөд мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх аргачлалын талаар мэдээлэлтэй талууд маш цөөхөн илэрсэн. Салбар ЭМБНХК-ийн цөөн гишүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ийн зүгээс ХБХ-ийг үнэлэх зарим аргуудыг нэрлэж байсан ч яг үнэлгээнд туршсан ашиглаж байгаа тохиолдол байсангүй.

## **2. Бодлогын судалгаа**

Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгээс ХБХ-ийн чиглэлээрх заалт, журамд баримт бичгийн шинжилгээг хийж, судалгааны үр дүнг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн ярилцлагаар баталгаажуулсан. Тус бодлогын судалгааг баримт бичгийн шинжилгээ болон чанарын мэдээлэл цуглуулалт гэсэн хоёр үе шаттайгаар 2016 оны 9 сараас 2017 оны 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгаагаар ХНХЯ-ны харьяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн /ХБИ/ хөгжлийн хэлтэс нь Монгол Улсын Засгийн Газрын /МУЗГ/ 2016 оны 11 сарын 09 ны өдрийн 136 тоот тогтоолоор Ерөнхий сайдын/ЕС/ дэргэдэх ХБИ-ийн зөвлөлийн ажлын алба болж салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах эрхтэй болсон хэдий ч яамдын ажлын уялдааг хангаж, нэгдсэн зохицуулалт хийхэд зөвлөлийн эрх мэдэл нь хүрэлцэхгүй байгаа нь харагдсан. Мөн яамд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаанаас гадна төрийн болон ТББ, олон улсын байгууллага /ОУБ/ хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо ихээхэн сул байгаа үр дүн гарсан.

## **3. Олон улсын туршлага судлах судалгаа**

Австрали, Ирланд, Тайланд, АНУ гэсэн дөрвөн улсын ХБХ-ийг тэгш хамруулан сургах боловсролын бодлогот харьцуулсан судалгааг 2016 оны 09-11 саруудад хийж гүйцэтгэсэн. Дараах шалгуур үзүүлэлтээр онлайн эх сурвалж дээр үндэслэн мэдээлэл цуглуулж анализ хийв:

- ХБХ-ийн үнэлгээтэй холбоотой дүрэм журам
- ХБХ-ийг үнэлэхэд ашиглаж байгаа арга, аргачлал
- ХБХ-ийн үнэлгээн дэхь оролцогч талууд

Судалсан улсуудын нийтлэг туршлагаар хүүхдийн хэрэгцээнд нийцүүлсэн боловсролын үйлчилгээг хүргэхэд сургууль болон тусгай боловсролын төвүүд /ТБТ/ хоорондын хамтын ажиллагаа ихээхэн өндөр түвшинд байна. Сургууль дээр хүүхдийн бэрхшээлийг анхан шатны түвшинд илрүүлэх үнэлгээний баг ажилладаг бөгөөд тус багийн үнэлгээгээр хүүхдэд дараагийн

түвшний нарийн үнэлгээ шаардлагатай гэж үзвэл тухайн орон нутаг дахь тусгай боловсролын төвүүдэд ханддаг байна. Албан ёсны оношилгооны баг нь хүүхдийн эмч, тусгай боловсролын багш, сэтгэл зүйч болон засалч зэрэг мэргэжилтнүүдээс бүрддэг. Мэргэжилтнүүдийн багийн үнэлгээгээр ХБХ-тэй хэрхэн ажиллах аргазүйн зааварчилгаа, зөвлөгөөг сургуулиудад хүргүүлэн, хүүхдийг өөрсдийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн байдлаар хөгжүүлэхийн төлөө шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг сайн туршлагаууд байна.

#### **4. Ажлын хэсэг**

Төслийн гол зорилтын биелэлтийг хангах зорилгоор ХБХ-ийг анхан шатны түвшинд илрүүлэх аргачлалыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт ХБХ-ийн боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд болон дүүргийн засаг даргын тамгын газрын /ЗДТГ/ төлөөлөл болон холбогдох ТББ-ын төлөөллүүд багтсан.

ХБХ-ийг илрүүлэх олон талт аргачлалуудыг судласны дүнд ажлын хэсгийн зүгээс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн /НҮБХС/ аргазүйн хүрээнд боловсруулагдсан хүүхдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй аливаа эрсдлийг тодруулах зорилготой "Вашингтон бүлэг-Хүүхдийн үйл ажиллагаа" модулийг төслийн хүрээнд ашиглахаар сонгосон. Тус аргачлал нь анхан шатны түвшинд хүүхдийн бэрхшээлийг илрүүлэх энгийн аргачлал бөгөөд олон улсад туршигдсан, НҮБХС-ийн зүгээс улс орнуудад санал болгож буй илрүүлэх аргачлал юм.

#### **5. Илрүүлэх аргачлалыг турших**

Туршилт үнэлгээг зорилтот есөн сургуулийн 500 хүүхдийн дунд 2017.02-2017.03 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж дууслаа. Хүүхдүүдийг түүвэрлэхдээ дараах гурван бүлэгт хувааж авч үзсэн: ХБХ, Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй эрсдэлтэй хүүхдүүд болон ердийн хүүхдүүд. Төслийн багийн зүгээс аргачлалыг ашиглах аргазүйг сургуулийн багш, нийгмийн ажилтнуудад олгон талбарын үнэлгээг зорилтот сургуулиудтай хамтран зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулах ажил явагдаж дууссан одоогоор үр дүнг боловсруулах, тайлан бичих ажлууд явагдаж байна.

Цаашид туршилтын үр дүн дээр үндэслэн аргачлал болон ашиглах гарын авлагыг эцэслэж, хэвлэн дүүрэг, хороо, сургуулийн багш ажилчид, эцэг эх зэрэг хүүхэдтэй хамгийн ойр ажилладаг анхан шатны нэгжийн мэргэжилтнүүдэд аргачлалын аргазүйг олгох сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

#### **Цаашдын чиглэл**

ХБХГИ төслийн хүрээнд дээр дурдсан олон талт ажлуудыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхээр зорьж байна:

Нэгдүгээрт илрүүлэх аргачлалын хэрэглээ өргөн хүрээтэй нэвтэрснээр ХБХ-ийн тоо статистик тодорхой, үндэслэлтэй гарах боломж бүрдэх юм. Хоёрдугаарт салбар ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүд тодорхой болох буюу хүүхдийн бэрхшээлийг тодорхойлох үндэсний механизм сайжирна гэж үзэж байна. Хамгийн гол үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй эсэх нь тодорхойлогдоогүй байсан хүүхдүүдийн бэрхшээлийг таньж мэдсэнээр цаашид тэдгээр хүүхдүүдийг тусгай хэрэгцээнд нь нийцүүлэн үр дүнтэй сургах боломж бүрдэнэ гэж найдаж байна.